БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 09 өдөр Дугаар А/189 Улаанбаатар хот

**Багахангай дүүргийн замын хяналтын постод тээврийн хэрэгслийн дугаар илрүүлэгчтэй болон дундаж хурдны камерын шилэн кабел, тэжээлийн эх үүсвэрт хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн, нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын чанартай А0101 автозамын хяналтын постын дундаж хурдны камер, дугаар илрүүлэгчтэй камерын тэжээлийн кабель, шилэн кабель холбох ажлыг зохион байгуулсугай.

2.Дундаж хурдны камерын шилэн кабель, тэжээлийн кабелд зарцуулах төсвийг хавсралтаар баталж, шаардагдах 5,990,000 (Таван сая есөн зуун ерэн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3.Ажлыг чанар үр дүнтэй хийж хэрэгжүүлж, санхүүгийн тайлан, холбогдох баримтыг ажил хийгдэж дууссанаас хойш ажлын 5 өдөрт багтаан тайлагнахыг Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн хэсэг (Цагдаагийн дэд хурандаа Д.Билгээ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

AJIL\2024 он ажил\захирамж

11232ᴼᴼ45ᴼ

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 10 сарын 09 ны өдрийн А/159 дугаар
захирамжийн хавсралт

# АМЫН ХЯНАЛТЫН ПОСТОД ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДУГААР ИЛРҮҮЛЭГЧТЭЙ БОЛОН ДУНДАЖ ХУРДНЫ КАМЕРЫН ШИЛЭН КАБЕЛ, ТЭЖЭЭЛИЙН ЭХ ҮҮСВЭРТ ШААРДАГДАХ ТӨСӨВ

| № | Нэр, төрөл | Байршил | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | 8 кор Агаарын шилэн кабель /8 Core Fiber Optic Cable | Замын цагдаагийн постны зүүн талын П-хэлбэрийн шон, Баруун талын Г-хэлбэрийн шон | 400 м | 3,200 | 1,280,000 |
| 2 | Тэжээлийн кабель /булах/ | Замын цагдаагийн постны зүүн талын П-хэлбэрийн шон, Баруун талын Г-хэлбэрийн шон | 400 м | 3,500 | 1,400,000 |
| 3 | Ажлын хөлс | Замын цагдаагийн постны зүүн талын П-хэлбэрийн шон, Баруун талын Г-хэлбэрийн шон | 2 ажилтан | 650,000 | 1,300,000 |
| 4 | Элс | Замын цагдаагийн постны зүүн талын П-хэлбэрийн шон, Баруун талын Г-хэлбэрийн шон | 35 Куб | 22,000 | 770,000 |
| 5 | Элс татах зардал | Замын цагдаагийн постны зүүн талын П-хэлбэрийн шон, Баруун талын Г-хэлбэрийн шон | 1 Хово | 670,000 | 670,000 |
| 6 | Экскаватор | Замын цагдаагийн постны зүүн талын П-хэлбэрийн шон, Баруун талын Г-хэлбэрийн шон | 3 цаг | 190,000 | 570,000 |
| Нийт | | | | | 5,990,000 |